



USAID
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



Эдийн засгийн бодлогын шинэтгэл,
өрсөлдөх чадварын төсөл

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2007 ОНЫ 3 ДУГААР САР

Монголын ноолуурыг Нью-Йорк хотноо сурталчиллаа

Монгол улсын ноолуурын салбарт тэргүүлэгч дөрвөн компанийн төлөөлөгчид 3 дугаар сарын 12-17-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо зочилж, АНУ-ын хамгийн нөлөө бүхий хувцас үйлдвэрлэгч, загвар зохион бүтээгч, борлуулагчдад өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцууллаа.



Дээрх дөрвөн компани нь Монголын Файбермарк нийгэмлэгтэй хамтран энэхүү үзэсгэлэнг зохион байгуулсан юм. Тэд монголын ямааны ноолуур, тэмээний ноос, сарлагийн хөөврөөр Монгол улсад үйлдвэрлэсэн цамц, ороолт, шааль, хөнжлийг дэлгэн үзүүлэв. Алтай кашмир, Говь корпораци, Гоёо, Эзио Форадори компани нь дотоодын бүтээгдэхүүнд шинэ зах зээл нээх, олон улсын брэнд бүтээгдэхүүн эзэмшигчид, тэдгээрийн үйлчлүүлэгчдээс шаарддаг чанарын стандартад хүрэхэд нь компаниудад туслах, техникийн туслалцаа үзүүлэх зорилготой Ноолууран хувцсыг зах зээлд гаргах ЭЗБШӨЧ төслийн хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хүлээн авагч буюу хөтөлбөрт хамрагдсан компаниуд юм.

Дээрх үзэсгэлэнг Нью-Йорк хотын бэлэн хувцасны худалдаагаар алдартай дүүрэгт зохион байгуулсан бөгөөд бэлэн хувцасны брэндийн олон тооны нэртэй худалдан авагчид оролцов. Энэ үйл ажиллагаанд оролцсон нэртэй компаниудаас зөвхөн цөөн хэдийг дурьдвал Saks Fifth Avenue, Brooks Brothers, Polo Ralph Lauren, Bloomingdales, Liz Claiborne, Perry Ellis компаниуд байв.

Сүүлийн гурван жилд ноолуурын салбарт томоохон өөрчлөлт гарч байна. Уламжлалт ойлголтоор Монгол улс нь гадаадын улс орнуудад, тухайлбал Их Британи, Италийн хувьд түүхий эд нийлүүлэгч улс гэж тооцогддог байсан бол одоо шинэ үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмжийн шинэчлэлд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж, илүү эрч хүчтэй удирдлага, олон улсын туршлагыг нэвтрүүлснээр энэ салбар нь эцсийн бүтээгдэхүүн болон тэдгээрийн дагалдах чимэглэл хэрэгслүүдийг үйлдвэрлэх чиг хандлагатай болж өөрчлөгдөж байна. Монголын загвар зохион бүтээгчид нь олон улсын загварын салбарын чиг хандлагыг мэддэг болж, бүтээгдэхүүний нарийн хийц, төгсгөлийг сайн хардаг болсноор бүтээгдэхүүний чанар сайжирч байна. Ноолууран хувцсыг зах

зээлд гаргах хөтөлбөрийн нэг хэсэг болох төслийн хүрээнд хувцасны өнгө, хийц загварын талаар жил бүр мэдээлэл цуглуулж, ирэх улирлуудад зонхилох өнгө, загварын талаархи таамаглалыг үйлдвэрлэгчдэд хүргэж байна.

Дээрх компаниудын хувьд худалдааны энэхүү арга хэмжээг зохион байгуулж, худалдан авагчидтай биечлэн уулзаж байсан уулзалтуудаас гадна "АНУ-д бизнес эрхлэх нь" сэдэвт семинарт оролцон, бүтээгдэхүүний баглаа боодол, шошго, бүтээгдэхүүнийг найдвартай хүргэх ач холбогдлын талаар илүү ойлголттой болох, мэдлэг хуримтлуулах зорилгоор борлуулалтын томоохон төвд айлчлах боломж ч мөн тохиосон юм.

Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг байгуулах Ажлын хэсгээс Үндэсний Хөтөлбөрийн төслийг батлав

Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг байгуулах Ажлын хэсгийн энэ улирлын хоёрдахь удаагийн хуралдаан 3-р сарын 29-ний өдөр Сангийн яаманд болж, Үндэсний хөтөлбөрийн төслийг батлав. Хуралдааныг Сангийн сайд Д. Баяртсайхан удирдан явууллаа.



Хуралдаан дараахь бүрэлдэхүүнтэй байв. Үүнд:

- Ч. Сайханбилэг, Ажлын хэсгийн ахлагч бөгөөд Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар (МХХТГ)-ын дарга
- С. Дэмбэрэл, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (МУХАҮТ)-ын дарга
- Б. Энхмандах, Байгаль орчны дэд сайд
- Я. Содбаатар, Үйлдвэр, худалдааны дэд сайд
- Б. Баттөмөр, Улсын Гаалийн ерөнхий газар (УГЕГ)-ын дарга
- Л. Зориг, Үндэсний Татварын ерөнхий газар (ҮТЕГ)-ын дарга
- Г. Гантөмөр, Стандарт хэмжил зүйн төв (СХЗТ)-ийн дарга
- Ж. Энхбаяр, Улсын Мэргэжлийн хяналтын газар (УМХГ)-ын дэд дарга

Энэхүү нийтлэлд илэрхийлсэн санал бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын санал бодлыг заавал тусгасан байх албагүй болно.

- С. Алтангэрэл, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бөгөөд Улсын Гаалийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн хэлтсийн дарга (УГЕГ)

Үндэсний хөтөлбөрийн төсөлд дараахь зөвлөмжүүд орсон. Үүнд:

1. Хэрэгжилтийг удирдан чиглүүлэх аж ахуйн нэгжийн "бизнес загвар"-ын талаархи шийдвэрийг аль болох эрт гаргах.

Ажлын хэсгээс олон улсын хэмжээнд амжилтад хүрсэн туршлагаудыг судалсны эцэст "Байгуул, Ажиллуул, Дамжуул" буюу ВОТ загварыг Монгол улсад хэрэглэх боломжтой гэж зөвлөмж болгосон юм. Энэ загварын хувьд стратегийн түнш болон гол хөрөнгө оруулагчид нь одоо байгаа технологийн тогтолцоог ашиглан, шаардлагатай хөрөнгө оруулалт хийж, уг системийг концессийн журмаар хэдэн жил ажиллуулсны дараа гэрээнд заасны дагуу Засгийн газарт хүлээлгэн өгнө. Засгийн газрын хувьд төсвийн ачааллыг багасгах, хамгийн орчин үеийн дэвшилтэт, ноу-хау технологи нэвтрүүлэх, үндэсний хүний нөөцийг хөгжүүлэх давуу талтай юм.

2. Бие даасан, хувьцаат, ашгийн төлөө компани байгуулах.

Олон улсын хэмжээнд амжилттай хэрэгжсэн туршлагаас үзэхэд энэ компанийн нийтлэг онцлог нь засгийн газрын агентлаг хоорондын зохицуулалтыг хялбаршуулсан, удирдах дээд байгууллага болон улс төрийн нөлөөллөөс харьцангуй ангид үйл ажиллагаа явуулж байна.

3. Улсын ба хувийн салбарын түншлэл (УХСТ) бүхий шинэ компанийг байгуулах.

Төр нь энэ компанийн хянагч биш харин түүний хувьцааг эзэмшигч байна. Монгол Улсын Засгийн газрын хувьд энэ туршлагыг ашгийн төлөө УХСТ-ийн компаниудыг бусад салбаруудад байгуулах бүтцийн өөрчлөлт хийх туршилт болгон ашиглах хамгийн эхний бодит боломж бий болж байна. Хувьцаат компанийн ийм бүтцийг бий болгоход хууль эрх зүйн болон зохицуулалтын орчинтой холбоотойгоор олон тооны асуудлууд гарах учраас хялбар биш юм. Гэхдээ иймэрхүү бүтцийн өөрчлөлт хийсэн туршлага, сурсан зүйлүүд нь цаашид компаниудыг УХСТ-ийн хэлбэрт шилжүүлэх бүтцийн өөрчлөлт хийхэд үнэтэй сургамж болох юм.

4. УХСТ-ийн компани дахь Засгийн газрын хөрөнгийг хэлэлцэн тохиролцох.

УИХ-аар батлагдсаны дараа Азийн Хөгжлийн Банкны гаалийн удирдлагыг сайжруулах төслийн зээлээс зарим хэсгийг (худалдан авсан тоног төхөөрөмж) нь ашиглах боломжийг бүрдүүлэх талаар дахин хэлэлцэн тохиролцож, түүгээрээ УХСТ-ийн компани дахь Засгийн газрын хөрөнгийн оролцоог хангах нь зүйтэй. Олон улсын хэмжээнд энэ туршлага өмнө нь Гана улсад хэрэгжсэн бөгөөд тухайлбал Дэлхийн Банкны зээлийн хөрөнгөөр худалдан авсан барааг УХСТ компанид нийлүүлж, түүний өртгийг Засгийн газраас тухайн шинэ компанид оруулсан хөрөнгө гэж тооцжээ. Компанийн үйл ажиллагааны орлогыг зээлийн эргэн төлөлтөд ашиглах замаар төсвийн зээлийн өрийн дарамтыг багасгах юм.

5. Боломжит стратегийн түнш болон хөрөнгө оруулагчийг тодорхойлох, хэлэлцээ хийх.

Ажлын хэсгээс гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхыг байгуулах (ГХХЦНЦ) Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах явцад олон улсын хэмжээнд амжилттай хэрэгжсэн туршлагауд, технологи, улс орнуудыг тодорхойлсон юм. Монгол улс нь эдгээр туршлага, баталгаатай технологийг нэвтрүүлснээр хэрэгжилтийн үе шатны хугацааг богиносгох боломжтой юм. Монгол улс нь "дугуйг дахин шинээр бүтээх" талаар цаашид ярилцах шаардлагагүй боловч дээрх технологийг нэвтрүүлэх, операторуудыг сонгох боломжуудыг судлан, тэдэнтэй өөрийн улс орны нөхцөл байдалд хамгийн тохиромжтой нөхцлөөр хэлэлцээ хийх нь чухал юм. Бие даасан, хувьцаат, ашгийн төлөө УХСТ-ийн компанийг байгуулах шийдвэр гарсны дараа компани нь ГХХЦНЦ-ны үзэл баримтлалыг амжилттай хэрэгжүүлж чадах зохих

технологи, баталгаатай ноу-хау бүхий санхүүгийн боломжтой операторууд, хөрөнгө оруулагчидтай хэлэлцээ хийнэ.

6. Монголын хувийн хэвшлийн, зохих ур чадвартай хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрийн сонирхлыг татах.

Монгол улсын хувийн хэвшлийн хөрөнгөтэйгөөс гадна, мэргэжлийн зохих ур чадвартай, компанид хөрөнгө оруулж чадах хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахад бүхий л хүч чармайлтаа гаргах ёстой. Монгол улсын бизнесийн байгууллагуудын дээд байгууллага болох Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим (МҮХАҮТ) нь хувийн хэвшлийн бизнесийг төлөөлж хувьцаа эзэмшигч болж болох боловч Монгол улсын компаниудад оролцох боломжийг олгож, компаниудыг нэмж тодорхойлох нь зүйтэй юм.

7. Цахим нэг цонхны үйлчилгээг хэрэгжүүлэхэд түүний үзэл баримтлал, туршлагын талаар олон нийтэд таниулан сурталчлах компани ажил явуулах, хэлэлцүүлэг хийх.

Хэвлэл мэдээллийн сонгосон хэрэгслүүдийг (сонингийн нийтлэл, ярилцлага, телевиз, радиогоор сурталчлах гэх мэт) ашиглан бодлого боловсруулагчид болон олон нийтэд энэхүү үзэл баримтлалын асуудлаар болон үзэл баримтлалыг ойлгуулах, дэмжлэг авах зорилгоор олон нийтийн сургалт сурталчилгааны компани ажил явуулна. Эдгээр компани ажил нь Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал болгож тодорхойлсон зорилтот хэсэг, бүлгүүдэд хандсан байвал зохино. Олон нийтэд таниулан сурталчлах болон үндэсний хэлэлцүүлгийн зарим ажлыг Швейцарийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй нэг цэгийн зөвшөөрлийн үйлчилгээний хөтөлбөрийн туршилтын төсөлтэй холбож болох юм.

8. Цахим нэг цонхны үзэл баримтлалын хэрэгжилтийг хангах хууль эрх зүйн болон зохицуулалтын орчинг бүрдүүлэхэд шаардлагатай зохих өөрчлөлтүүдийг тодорхойлох

Бизнес загвар болон УХСТ-ийн хувьцаат, ашгийн төлөө компани байгуулах шийдвэр гарсны дараа одоо үйлчилж буй хууль, журмуудыг аль болох богино хугацаанд дахин судалж үзэх шаардлагатай юм. Хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлахдаа юуны өмнө дараахь зүйлүүдэд анхаарвал зохино. Үүнд:


- Гадаад худалдааг хөнгөвчлөх цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх баталгааг хангахын тулд гаалийн тухай хуулийн санал болгосон төслийг судлах
- Төслийн санхүүгийн дэд бүтцийг бүрдүүлэх, ВОТ болон ВОО ("байгуул, ажиллуул, эзэмш") загварыг бусад загваруудаас сонгож, тэдгээрт тохирсон эрх зүйн болон зохицуулалтын хүрээг бий болгох зорилгоор концессийн тухай хуулийн төслийг хянах
- Е-Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд багтаж буй е-бизнес, е-цахим гүйлгээний талаар үйлчилж буй одоогийн хууль, тогтоомжуудыг судлах
- Үйл ажиллагааг хялбарчлах, давхардал гаргахгүй байх, хариуцлагыг тодорхой болгох зорилгоор оролцогч агентлагуудын эрх зүйн болон зохицуулалтын чиг үүргийг судлах
- Цахим нэг цонхны үйлчилгээг зохих ёсоор явуулах баталгааг хангахын тулд одоогийн үйлчилж буй холбогдох хууль, тогтоомжуудыг ерөнхийд нь судалж хянах

Ажлын хэсгээс Үндэсний хөтөлбөрийн төслийн талаар хэлэлцэн, санал бодлоо солилцсоны эцэст батлав. Сангийн сайд Н. Баяртсайханаас Засгийн Газрын хуралдаанаас гаргах тогтоолын төслийг боловсруулж, АХ-ийн нийт гишүүдээс санал авч эцэслэн танилцуулахыг даалгав.

Эрчим хүчний зохицуулах газар таван жилийн үйл ажиллагаандаа өндөр үнэлгээ авав

Монгол улсад анхны бие даасан зохицуулах газар байгуулагдаад тавхан жил өнгөрч байгаа хэдий ч саяхны тайланд тус газрын үйл ажиллагаанд өндөр үнэлгээ өгчээ. Энэхүү газрын үйл ажиллагааг үнэлэхдээ өгсөн заавар, зөвлөмж, олон улсын шилдэг туршлагыг харгалзсан байдал зэргийг анхааран үзсэн тухай "Эрчим Хүчний Зохицуулах Газрын үйл ажиллагааны үнэлгээний тайланд" дурьдаад дараах дүгнэлтийг гаргажээ. Үүнд:

*"ЭХЗГ богино хугацаанд маш чадварлаг эрх бүхий байгууллага болон хөгжиж чаджээ. Тус газраас багц дүрэм журам боловсруулж гаргаснаас гадна тариф батлан, тусгай зөвшөөрөл олгож, хэрэглэгчдээс гарсан маргаан, гомдлыг шийдвэрлэжээ. Энэхүү үнэлгээний дагуу үр ашгийн 6 үзүүлэлтээр эрчим хүчний салбарт оролцогч бусад байгууллагуудаас ЭХЗГ илүү оноо авчээ. Үнэлгээний бүх үзүүлэлтээр ЭХЗГ сайн эсвэл маш сайн гэсэн үнэлгээ авсан байна."*¹



Эрчим хүчний зохицуулах газар гэж ямар байгууллага вэ?

Эрчим хүчний зохицуулах газар (ЭХЗГ) нь 2001 оны Эрчим хүчний тухай хуулийн 5.12 дугаар заалтын дагуу гаргасан Засгийн газрын 83 дугаар тогтоолоор 2001 оны 4 дүгээр сарын 16-нд байгуулагджээ. ЭХЗГ нь Монгол улсыг эрчим хүчээр хангадаг Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС), зүүн бүсийн эрчим хүчний систем (ЗБЭХС) ба баруун бүсийн эрчим хүчний системүүдийн (ББЭХС) үйл ажиллагааг удирдан зохицуулдаг. Аймаг, нийслэлийн бусад жижиг зохицуулах зөвлөлүүд зөвхөн дулаан үйлдвэрлэдэг уурын зуух, сүлжээнд холбогдоогүй дулааны жижиг генераторуудын үйл ажиллагааг удирддаг. ЭХЗГ Монголын эрчим хүчний системийг ерөнхийд нь удирдан зохицуулж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 8.1 дүгээр заалтад ЭХЗГ эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг

¹Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар төсөл. "Эрчим хүчний зохицуулах газрын үйл ажиллагааны тайлан." Улаанбаатар хот, Монгол Улс. 2006 оны 11 дүгээр сар, ху. 47.

үүрэгтэй гэж заажээ. Тус газар нь үйлдвэрлэлээс эхлээд хэрэглэгчдэд хүргэх хүртэл эрчим хүчний бүх шатны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрхтэй бөгөөд тусгай зөвшөөрөл олгох, тариф тогтоох, маргаан гомдлыг шийдвэрлэх үүргийг мөн хүлээдэг,

Засгийн газрын бүтэц, яамны удирдлагаас саланги, тусгай эрх мэдэл бүхий байгууллага Монголд урьд нь байгаагүй тул 2001 онд ЭХЗГ байгуулагдсан явдал тус орны хувьд цоо шинэ үзэл баримтлал байсан юм. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуучин Дэд бүтцийн яамны дэргэд байгуулагдаж байжээ.


Яам, засгийн газрын ердийн бүтцээс ангид ЭХЗГ-ын бие даасан энэхүү байдал нь "зохицуулах газрын үйл ажиллагаанд нөлөөлөх эсхүл түүний үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журмыг тодорхой болгож тус газрын бие даасан байдлыг хамгаалах нь зүйтэй боловч тус газар үйл ажиллагаагаа явуулахдаа аливаа хувь хүн, байгууллагын удирдлага, хяналтан дор байх ёсгүй" гэсэн олон улсын шилдэг туршлагад нийцэж байна. (Эх сурвалж: Мэри Вэбстэрийн гаргасан Эрчим хүчний зохицуулах газрын үйл ажиллагааны үнэлгээний тайлан). Өөрөөр хэлбэл, зохицуулах үйл ажиллагааг улс төрийн явцуу ашиг сонирхлоос ангид, төрийн яам, агентлагуудын оролцоо, нөлөөгүй хэрэгжүүлэх нь зүйтэй.

2001 оноос хойш ЭХЗГ Монголын эрчим хүчний салбарын өөрчлөлт шинэчлэлийн төвд байсан бөгөөд эрчим хүчний салбарын босоо удирдлагыг халах замаар эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үүрэг бүхий 18 шинэ нэгжийг удирдан зохицуулах үүргийг хүлээжээ.

ЭХЗГ-ын бүтэц, үйл ажиллагаа

Бүтэц, зохион байгуулалт. Зураг 1-д ЭХЗГ энгийн бөгөөд хялбар бүтэц, зохион байгуулалттайг харуулж байна. Ажлын ачаалал, шаардлагыг үл харгалзан уг газрын ажилчид таван жилийн турш тогтвортой ажиллажээ. Одоогийн байдлаар туслах ажилчдыг оруулахгүйгээр тус газар 29 ажилтантай бөгөөд үүнд 26 үндсэн ажилтан, Удирдах зөвлөлийн 3 гишүүн багтдаг.

Зураг 1: ЭХЗГ-ын бүтэц зохион байгуулалт



Ерөнхий сайдын томилсон гурван зохицуулах гишүүн бүхий Зохицуулагчдын зөвлөл ЭХЗГ-ын үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Эрчим хүчний тухай хуулинд "Зохицуулагчдын зөвлөлийн дарга, зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Ерөнхий сайд анхны томилгоог 2, 4, 6 жилээр, цаашид 6 жилийн хугацаагаар, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жилийн зөрөөтэйгээр дуусгавар болж байхаар томилно" гэж заажээ. Зохицуулагчдын зөвлөл олонхийн саналаар шийдвэр гаргана.

2001 оны Эрчим хүчний тухай хуулийн 8.5 дугаар заалтын дагуу ЭХЗГ-ын дэргэд зөвлөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байгуулагджээ. Энэхүү зөвлөл нь хэрэглэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн (эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах компаниуд) тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн 8 гишүүнтэй.

Зөвлөх зөвлөлийн гол үйл ажиллагаа ЭХЗГ-т өнөөгийн тулгарч буй асуудлыг нягтлан хянаж, гарч болзошгүй асуудлыг урьдчилан харах, хэрэглэгч болон тусгай зөвшөөрөл

ЭХЗГ Стерн, Холдер нарын санал болгосон зохицуулалтын засаглалын дараахь 6 үзүүлэлтийг ашиглажээ. Үүнд:

1. Зорилт ба үүргийн тодорхой байдал,
2. Зохицуулагчдын хараат бус байдал,
3. Олон нийтийн оролцоо,
4. Зохицуулах байгууллагын хариуцлага
5. Үйл ажиллагааны ил тод байдал,
6. Гарах үр дүнг урьдчилан таамаглах байдал.

ЭХЗГ байгуулагдсанаасаа хойш 5 жилийн хугацаанд хир сайн ажилласан бэ? Гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг тэгээс тав хүртэлх оноогоор үнэлсэн бөгөөд 5 нь хамгийн өндөр, 0 нь хамгийн сул гэсэн үнэлгээ юм:

- 5.00 хамгийн өндөр оноо
- 0.00 хамгийн бага оноо
- 2.50 ба дээш бол дундаж үзүүлэлтээс дээгүүр
- 3.50 ба дээш бол гүйцэтгэл маш сайн
- 4.00 ба дээш бол гүйцэтгэл онц сайн
- 2.50-аас дээш оноо нь гүйцэтгэл дунджаас дээш буйг харуулж байгаа бөгөөд цахилгааны үйлдвэрлэлийн хүчин чадалд оруулах хөрөнгө оруулалт дунджаас дээгүүр байгааг харуулдаг.

1. Зорилгын тодорхой байдал: оноо: 2.90

Зорилгын тодорхой байдлыг харуулж буй үзүүлэлтийн нийт 5.00 онооноос дундаж 2.90 оноог авчээ. ЭХЗГ-ын энэ үзүүлэлт нь дундаж онооноос бага зэрэг өндөр байна. Яамны оролцоо, гүйцэтгэх үүрэг тодорхой бус байсантай холбоотойгоор гүйцэтгэлийн үзүүлэлтэд доогуур оноо өгчээ. 2001 онд батлагдсан Эрчим хүчний тухай хуулиар зарим үүрэг хариуцлагыг ЭХЗГ-т, заримыг нь Төрийн захиргааны төв байгууллага хариуцахаар заасан юм. Үндэсний хууль тогтоомжийн тодорхойгүй байдал нь гүйцэтгэлийн үзүүлэлтэд нөлөөлөх нэг хүчин зүйл болжээ. Эрчим хүчний салбарт оролцогч бусад талуудын үйл ажиллагааны хүрээ, чиг шугамын тодорхой байдал гүйцэтгэлийн энэхүү үзүүлэлтэд нөлөөлөх чухал гол хүчин зүйл юм. ЭХЗГ нь өөрийн зорилгыг тодорхой болгох талаар маш их хүч чармайлт гаргасан байна. Гэхдээ цахилгаан эрчим хүчний салбарт оролцогч бусад талууд ЭХЗГ-ын зорилго, дүрэм, журам, өөрчлөлт шинэчлэл болон бодлогын аль болох тогтвортой байлгах талаар мөн тодорхой мэдэж байх шаардлагатай.

2. Хараат бус байдал: оноо: 3.12

Хараат бус байдлыг харуулсан үзүүлэлтээр дундаж 3.12 оноо авчээ. ЭХЗГ нь энэ үзүүлэлтээр дундаас дээш оноо авсан бөгөөд эрчим хүчний салбар дахь өөрийн хараат бус байдлаа харуулахын тулд тодорхой алхмууд хийсэн байлаа. Гэхдээ ЭХЗГ-ын төсөвлөлтөд улс төрийн оролцоо нөлөөлж буй байдал уг газрын төсвийн хараат бус байдлыг алдагдуулж байгаа нь энэ үзүүлэлтэд нөлөөлсөн байна.

3. Олон нийтийн оролцоо: оноо: 3.70

ЭХЗГ нь энэ үзүүлэлтээр дундаас дээгүүр оноо авсан бөгөөд ялангуяа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн оролцоог дэмжих талаар гаргасан хүчин чармайлтаар хамгийн өндөр оноо авч чаджээ. Үнэлгээнд оролцсон зарим хүмүүс олон нийтээс ирүүлсэн санал бодолд илүү анхааралтай хандсан бол олон нийтийн оролцоог илүү идэвхжүүлж болоа байсан.

4. Хариуцлага: оноо: 4.10

ЭХЗГ нь энэ үзүүлэлтээр өндөр оноо авчээ. Зөвхөн таван жил үйл ажиллагаа явуулж буй зохицуулах байгууллагын хувьд 4.10 гэдэг их өндөр оноо юм. Зохицуулах газар үйл ажиллагааны жилийн тайланг дэлгэрэнгүй байдлаар хэвлэн нийтэлж тайлагнаж буй нь тэднийн хариуцлагатай байдлыг харуулж байна. Энэ үзүүлэлтээр хамгийн өндөр оноо авч чадаагүй нь ЭХЗГ харьцангуй шинэ байгууллага байгаатай холбоотой.

5. Ил тод байдал: оноо: 3.83

ЭХЗГ нь энэ үзүүлэлтээр сайн оноо авчээ. ЭХЗГ-аас тушаал, шийдвэр гаргаж буй байдал ил тод байдаг үзүүлэлтээр сайн оноо авсан боловч гарсан баримт материалын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтийн хүртээл болгох үзүүлэлтээр арай доогуур оноо авчээ. Ялангуяа төрийн өмчит компаниудын хувьд олон нийтийн хүртээл болгохгүй нууцлах мэдээлэл байх ёсгүй юм.

6. Гарах үр дүнг урьдчилан таамаглах боломж: оноо: 3.71

ЭХЗГ нь энэ үзүүлэлтээр сайн оноо авчээ. ЭХЗГ тууштай үйл ажиллагаа явуулдаг байдал үүнд нөлөөлжээ. Гэхдээ эрчим хүчний салбарын зохицуулалтад улс төрийн оролцоо, нөлөөлөл байх тохиолдолд гарах үр дүнг урьдчилан таамаглах боломжгүй болгодог. Энэ нь хөрөнгө оруулагчдын хувьд Монгол улсын эрчим хүчний салбарт амжилттай хөрөнгө оруулалт хийх итгэлийг бууруулахад хүргэж болзошгүй юм.

Хэдийгээр ЭХЗГ зөвхөн таван жилийн хугацаанд үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч маш сайн ажилласан гэсэн үнэлгээ авчээ. Энэхүү зохицуулах байгууллагын нэр хүнд өсч, Төв Азийн бүсийн орнуудын дунд хамгийн шилдэг байгууллагаар шалгарсан байна.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та манай цувралын талаархи өөрийн санал бодлоо, мөн манай цувралыг захиалах болон захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү. Имэйл: fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.